



**Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН
УРАН БҮТЭЭЛЧИД, ЖҮЖИГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ТҮВШИН
ТОГТООХ ШАЛГАЛТЫН ЖУРАМ**

Баримт бичгийн нэр:	Уран бүтээлчид, жүжигчдийн мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтын журам
Баримт бичгийн хариуцагч:	Санхүү, хүний нөөцийн алба, Урын сангийн эрхлэгч
Баримт бичгийн дугаар:	№ 2025/02
Хамрах хүрээ:	Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчид, жүжигчид
Хуудасны тоо	5 хуудас
Боловруулсан:	2025 оны 9 сарын 25-ны өдөр
Баталсан огноо:	2025 оны 9 сарын 25-ны өдөр
Хянасан:	Уран сайхны удирдагч Б.Хишигзаяа:
Баталсан:	Захирал: Н.Наранбаатар



Өөрчлөлтийн талаарх мэдээлэл:

Өөрчлөлт ажилтан	оруулсан	Өөрчлөлт оруулсан огноо	Хувилбар	Өөрчлөлтийн утга

Жич: Энэхүү бичиг баримтыг зөвхөн Улсын драмын эрдмийн театрын дотоод хэрэгцээнд ашиглана.



“УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТР”-ЫН
УРАН БҮТЭЭЛЧИД, ЖҮЖИГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ТҮВШИН
ТОГТООХ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол түвшинг дээшлүүлэх, тухайн уран бүтээлчийн ажлын үр дүн, өсөлт, цаашдын төлөвийг тодорхойлж дүгнэхэд энэхүү шалгалтын зорилго оршино.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2.1 Уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, түүний үр дүнг гаргахад энэхүү журмыг баримтална.
- 2.2 Уран бүтээлчдийн ажлын арга барил, туршлага эзэмшсэн байдал, ур чадварын өсөлт, ажлын үзүүлэлтийг үнэлсэн мэргэжлийн ур чадвар тогтоох шалгалтын дүн нь тухайн ажилтны ажлын байр хадгалагдах, эс хадгалагдах буюу хөдөлмөрийн харилцааг хэвээр үргэлжлүүлэх эсхүл цуцлах үндэслэл болно.
- 2.3 Уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтыг 3 жил тутам зохион байгуулна.
- 2.4 Ажилласан жил, төрийн шагнал, боловсрол зэрэг цолыг үл харгалзан, уран бүтээлчдийг шалгалтад хамруулна. Эрэгтэй 60 нас, эмэгтэй 55-аас дээш насны уран бүтээлчид шалгалтад орохгүй бөгөөд өөрөө хүсвэл орж болно.
- 2.5 Жирэмсэн болон 3-аас доош насны хүүхэдтэй эмэгтэй ажилтныг шалгалтаас чөлөөлөх ба тухайн ажилтан нь хуулийн хугацаанаас өмнө ажилдаа өөрийн хүсэлтээр орсон бөгөөд цалинжиж буй тохиолдолд мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтад бусдын адил хамрагдах үндэслэл үүснэ.
- 2.6 Шалгалтын холбогдох баримт, дүнгийн хуудсыг тухайн уран бүтээлчийн хувийн хэрэгт хадгална.

ГУРАВ. ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Шалгалтыг УДЭТ-ын захирлын тушаалд заагдсан эсвэл тогтоосон хугацааны дотор хуваарийн дагуу зохион байгуулна.
- 3.2 Шалгалтын хугацааг болон удирдамжийг шалгалт эхлэхээс 2 сарын өмнө уран бүтээлчдэд мэдээлнэ.
- 3.3 Ур чадварын шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг 1 сараас доошгүй хугацааны өмнө захирлын тушаалаар батлуулна.
- 3.4 Жүжигчид, уран бүтээлчид нь ур чадвар, мэдлэг, гоо зүй, манлайллын түвшинг оноогоор дүгнүүлнэ.
- 3.5 Шалгалтыг дараах шалгуур үзүүлэлтээр тус бүрд нь оноо өгч нэгдсэн дүнг гаргана.
- 3.5.1 Мэдлэг (театрын онолын суурь мэдлэг, зохиолын задаргаа)
- 3.5.2 Жүжигчний ур чадвар (Монолог)
(Монголын театрын тайзнаа тавигдаагүй монгол болон дэлхийн сонгодог зохиолоос монолог сонгосон байх)
- 3.5.3 Тайзны хөдөлгөөн ур чадвар (Пластик зохиомж) 3-5 минут

УЛСЫН ДРАМЫН
ЭРДМИЙН
ТЕАТР
УХЖИ
17153453

(Тодорхой утга санаа агуулгыг биеийн уян хатан чанар хөдөлгөөний эвсэл, ур чадвараар илэрхийлнэ. 1-2 хүний бүрэлдэхүүнтэй байж болно)

3.5.4 Ярих, өгүүлэх ур чадвар (Ганцаарчилсан хошин үзүүлбэр)

Инээдмийн төрөл жанрын үзүүлбэр байна.

3.5.5 Хувь хүний хөгжил, харилцаа, хандлагын үнэлэмж

(Хувь хүн уран бүтээлчийн нэр хүнд, хамт олонд сайнаар үлгэрлэх чанар, нийтэч байдал, уран бүтээлч сэтгэлгээ, идэвх санаачилга, шинийг эрэлхийлэх чадвар зэргийг харгалзана.)

3.5.6 Сэтгэцийн эрүүл мэндийн шаардлага (СЭМҮТ, Сэтгэл судлалын үндэсний төв зэрэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана)Бие мах бодь, хөдөлгөөний эрүүл мэндийн шаардлага зэргээр шалгана.

3.5.7 Бие махбод хөдөлгөөний эрүүл мэндийн шаардлага (ГССҮТ-тэй хамтран ажиллах)

- 3.6 Шалгалтын явцыг камераар бичиж баримтжуулах ба бичлэг нь театрын архивд хадгалагдана.
- 3.7 Шалгалтын бичлэг үзэхийг хүсвэл бичгээр хүсэлт гаргаж зөвхөн өөрийн үзүүлбэрийг үзэх эрхтэй.
- 3.8 Шалгалт эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө шалгалтад хамрагдах хүний жагсаалтыг гаргаж, дор дурдсан материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
-2025 оны жилийн ажлын гүйцэтгэлийг нэгтгэн оноонд дүйцүүлж, баталгаажуулан УБХ-ийн дарга, туслах найруулагч, Ерөнхий найруулагч нар хүлээлгэн өгнө.
- 3.9 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ур чадварын шалгалтад ороогүй уран бүтээлчийг нөхөн шалгалт өгөх боломжоор хангана.
- 3.10 70-аас доош үнэлгээ авсан уран бүтээлчийг хуанлийн 30 хоногт дахин шалгалт өгөх боломж олгон хэрвээ дахин хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцална.
- 3.11 60-аас доош хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцална.
- 3.12 Шалгалтад ороогүй уран бүтээлчийг тэнцээгүйд тооцно.
- 3.13 Шалгуулагч нь оноогоо мэдэхийг хүсвэл бичгээр хүсэлтэй өгч, шүүгчийн эрх ашгийг хамгаалсан нэргүй тоон үзүүлэлттэй танилцана.
- 3.14 Шалгалтын явцад аливаа зөрчил илэрсэн бол Комисс нь яаралтай арилгах арга хэмжээ авах, ноцтой тохиолдолд УДЭТ-ын холбогдох дүрэм, журамд зааснаар шийдвэрлэнэ.
- 3.15 Шалгалтын явцад танилцсан байгууллага болон ажилтны нууцад хамаарах бүх мэдээллийг Комисс нь бусдад задруулахгүй чанд хадгална.

ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГ ТООЦОЖ, ДҮГНЭХ

- 4.1 Комиссын гишүүн бүр шалгалтад орж байгаа уран бүтээлч нэг бүрийн үйл ажиллагаанд энэ журмын 3.4-д заасан үзүүлэлтээр онооны үнэлгээ өгч, дүнг гаргана.

Онооны нийлбэр

90-100 оноо “А” Хангалттай сайн

80-89 оноо “В” Хангалттай

70-79 оноо “С” Дунд

60-69 оноо “D” Хангалтгүй

0-59 оноо “F” Маш хангалтгүй

РАМЫН
ТЕАТР

258
9037028

258
9037028

- 4.2 Мэргэжлийн ур чадварын шалгалтыг Улсын драмын эрдмийн театрын ажлын хэсгийн болон ур чадварын шалгалтын комиссын нэгдсэн дүнгээр дүгнэж, шалгаруулна.
- 4.3 Ур чадварын шалгалтын комиссын үндсэн бүрэлдэхүүн нь УДЭТ-ын уран бүтээлийн удирдлага мэргэжлийн экспертүүдээс бүрдэж нийлбэр оноог гаргана.
- 4.4 Комисс нь шалгалтыг явуулж дууссаны дараа ажлын 10 хоногт багтаан, шалгалтын дүн, тайланг гаргаж, хамт олонд танилцуулан, театрын захиргаанд 1 хувийг хүргүүлнэ. Тайланд ажилтан бүрийн шалгалтын дүн, тэдгээрийн ажлын ололт болон дутагдалтай талыг тэмдэглэж, шаардлагатай зөвлөмж өгсөн байна.
- 4.5 Шалгалтад хангалтгүй дүн үзүүлж, 70-аас доош буюу “D”, “F” үнэлгээ авсан нь уран бүтээлчийг Хөдөлмөрийн гэрээ цуцлах эсэхийг хөдөлмөрийн тухай хууль, УДЭТ-ын дүрэм, дотоод журмаар шийдвэрлэнэ.
- 4.6 Шалгалтын дүнг үндэслэн уран бүтээлчийн ур чадварын нэмэгдэл, ажлын байрыг өөрчлөх асуудлыг шалгалтын дүн гарснаас хойш 1 сарын хугацаанд багтаан, Захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 4.7 Комиссын гаргасан шалгалтын дүнг захиргааны байгууллага авч хэлэлцэх боловч, өөрчлөх эрхгүй.